

**“ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЖ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ”
(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ)**

А. Пагма, Г. Гэрэл, Б. Мөнхцэцэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-ийн 8 -д УИХ -ын “... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” онцгой бүрэн эрхийг хуульчилсан ба Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд¹³ туссан үндсэн 5 **зорилтын** 2 –т, “Парламентын хянан шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлнэ” гэж заажээ.

УИХ-ын стратеги төлөвлөгөөнд урт хугацааны уг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон чухал **зорилго** дурдагдсаны дотор,

- Парламентын хянан шалгах үйл ажиллагааны өнөөгийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, улмаар, эрх зүйн талаас нь тусгайлан зохицуулж шийдвэрлэх;
- Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагааг илүү ил тод, нээлттэй болгох; ... зэрэг тодорхой заалтууд орсон байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд УИХ-ын хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх зарчим, хэлбэрийг хуульчилжээ. УИХ нь хянан шалгах бүрэн эрхээ дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд,

- Засгийн газрын болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох;
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга тавих, түүний хариуг чуулганаар хэлэлцүүлэх;
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулт тавьж хариулт авах;
- Засгийн газрын болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллага, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянан шалгаж дүнг Байнгын хорооны, шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас томилогдсон, түүнд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, гишүүнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж санал, дүгнэлт гаргах зэрэг болно.

Түүнчлэн УИХ-ын тухай хуулинд зааснаар Байнгын хороод нь УИХ-ын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын ажлын хэсэг байгуулж ажиллуулах бүрэн эрхтэй ба дэд хороод нь хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй юм.

Улсын Их Хурал өөрийн хянан шалгах чиг үүргийг хангалттай сайн биелүүлж чадахгүй явсаар олон жил боллоо гэсэн шүүмжлэл олон түмний зүгээс байнга гарсаар иржээ. Энэ нь оргүй хоосон үг биш юм. 2010 онд УИХ –ын Тамгын газрын Судалгааны төвөөс гаргасан “УИХ –ын хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүдийн үйл

¹³ Улсын Их Хурлын 2002 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан

ажиллагааны талаархи статистик мэдээлэл” (1996 – 2009) –д, хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн “үр дүнгээ хэлэлцсэн байдал” –ыг тоон үзүүлэлтээр харуулсан. Тэнд, өнгөрсөн 13 жилийн хугацаанд байгуулагдсан 244 ажлын хэсгийн 14 нь “ажиллаагүй”, 60 нь “ажилласан эсэх нь тодорхойгүй” гэж тэмдэглэгджээ. Тэгэхээр, байгуулагдсан 3 ажлын хэсэг тутмын бараг 1 нь буюу 30.3% нь “үр дүнгээ өгөөгүй” сул үзүүлэлттэй байна. Ийм байдалд хүргэсэн 7 шалтгаан байгаагийн нэг нь, тэнд дурдсанаар, “хяналт шалгалтын үр дүнг үнэлэх нэгдсэн хэмжүүр, шалгуур үзүүлэлт байхгүй” –д оршиж байгаа ажээ¹⁴.

Гадаадын улс орнууд парламентын хяналт шалгалт, ялангуяа, парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаанд/ parliamentary investigation, парламентское расследование/ онцгой ач холбогдол өгч, түүнийг олон оронд тусгай хуулиар зохицуулсан байдаг. Дэлхийн олон улс орны парламент иргэдийн анхааралд нэгэнт өртсөн, нийгмийн хурц маргаан дэгдээсэн “ноцтой халуун” асуудлыг “өөрөө шалган тодруулж, холбогдох арга хэмжээг авах” эрхээ өөр өөрийн үндсэн хуулиндаа тусгасан байдаг¹⁵.

Парламентаас хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь түүний ажлын албаны зүгээс үзүүлэх үйлчилгээний хувьд УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 оны 73 дугаар захирамжаар батлагдсан Тамгын газрын хэлтэс, алба, төвийн чиг үүргийн дагуу Байнгын хороодын ажлын алба, Захиргаа боловсон хүчний хэлтэсийн чиг үүрэгт УИХ-ын хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх үүрэг тодорхойлогдсон байна.

Парламентын хяналт шалгалт гэдэг нь парламентаас засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт бөгөөд гадаадын парламентын практикт засгийн газрын үйл ажиллагаанд тавих бүхий л талын төлөвшсөн бүхэл бүтэн тогтолцоо ажиллаж засгийн газрын үйл ажиллагаа, төсвийн бодлого, түүний хэрэгжилт, төрийн үйл ажиллагааны бусад салбарт өөрийн бүрэн эрхийн хүрээнд хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлдэг байна.

Парламентын хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь засгийн газарт итгэл үзүүлэх эсэх талаар асуудал тавих, буруушаасан тогтоол батлах, парламентын гишүүний асуулга, засгийн газарт аман болон бичгээр асуулт тавих, парламентаас мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах зэрэг хэлбэртэй байдаг.

Гадаадын зарим улс орны туршлагаас үзэхэд парламентаас хяналт шалгалтын чиг үүргээ гүйцэтгэхэд нь ажлын албадын зүгээс үзүүлэх үйлчилгээ нь төрөл бүрийн хэлбэр, чиглэлтэй бөгөөд зарим орны парламент энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйлчилгээ тусламж үзүүлэх зорилго бүхий бие даасан нэгжтэй, зарим нь ийм тусгайлсан нэгжгүй боловч бусад бүтцээр дамжуулан үйлчилгээ үзүүлдэг байна.

Парламентаас хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь парламентын ажлын албадын үзүүлдэг дэмжлэг, үйлчилгээг зарим улс орны жишээн дээр авч үзье.

Шинэ Зеланд

Тус улсын парламентын Тусгай хороод нь парламентын хууль тогтоох, санхүүгийн, хяналт шалгалтын болон мөрдөн шалгах үүрэгтэй холбоотой хамгийн шуурхай ажлыг гүйцэтгэдэг. Танхим дахь хэлэлцүүлэг зөвхөн парламентын гишүүдээр хязгаарлагддаг бол тусгай хороод өөрийн үйл ажиллагаандаа олон нийтийг татан оролцуулж болдог. Хууль

¹⁴ Бодлогын судалгаа шинжилгээ IV боть, УБ., 2010 он, 317 дах тал

¹⁵ Хавсралт 2-оос үзнэ үү

тогтоох процесст парламентын гишүүд ийнхүү олон нийттэй харилцан ажилладаг нь Шинэ Зеландын парламентын онцлог юм.

Тусгай асуудлаар байгуулагдсан эдгээр хороодын үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ үзүүлэх нь парламентын ажлын албаны **Тусгай хороодын офисийн /Select Committee Office/** үүрэг ба шаардлагатай тохиолдолд бусад байнгын хороодод үйлчилнэ. Офис нь мөн тусгай хороодод процедур, тайлан бичих, зохион байгуулах ажлаар туслана. Офисийн ажилтнуудын хувьд хорооны хуралдааны материал бэлтгэх, хуралдааны бичлэг үйлдэх, судалгаа, анализын мэдээлэл, хорооны тайлан бэлтгэх зэргээс гадна тусгай хороодын гишүүдэд дүрэм, журам, парламентын процедурын практикаар зөвлөгөө өгнө.

Тусгай хороодын офисоос тусгай хороо бүрт ажилтан томилон ажиллуулна. Энэ ажилтан Танхимын клеркийг төлөөлөн ажиллаж, хариуцлага хүлээхээс гадна тусгай хорооны удирдлагын доор хорооны ажлыг зохицуулна. Тусгай хороодын хамгийн гол ажлын нэг болох Танхимд гарган өгөх тайланг энэ ажилтны удирдлага доор бэлтгэдэг байна.

Түүнчлэн парламентаас хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлдэг Парламентын офис ажилладаг ба энэ нь **Ерөнхий аудиторын офис, Омбудсмэний офис, Байгаль орчны парламентын комиссарын офис** гэсэн гурван парламентын офисоос бүрдэнэ. Эдгээр офис тус бүрийг Төлөөлөгчдийн танхимын зөвлөснөөр Мужын сайдын /Governor-General/ томилсон Парламентын албан тушаалтнаар удирддаг.

Ерөнхий аудиторын офис /Office of the Auditor-General/

Ерөнхий аудитор болон Ерөнхий хянагч /Controller/ нь бүх төрийн мэдлийн байгууллага, аж ахуйн нэгжийн төсвийн аудитор байна. Үүнд: Төрийн яамд, төв болон орон нутгийн төсвийн байгууллагууд хамрагдана.

Омбудсмэний офис /Office of the Ombudsmen/

Одоогоор хоёр Омбудсмэн томилогдон ажиллаж байгаа ба тэдгээрийн үүрэг нь Шинэ Зеландын төв болон орон нутгийн засгийн газрын байгууллагууд, агентлагуудаас гаргасан захиргааны шийдвэрүүдийн талаархи гомдлыг хянан шалгана.

Байгаль орчны парламентын комиссарын офис /Office of the Parliamentary Commissioner for the Environment/

Байгаль орчны парламентын комиссарын офис нь хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлсөн байж болох бүх асуудлыг мөрдөн шалгаж, илтгэл тайлан бэлтгэн парламентад танилцуулах өргөн хүрээний эрх мэдэлтэй болно. Мөн Байгаль орчны парламентын комиссарын офис нь парламентын Тусгай хороодод хүрээлэн буй орчны асуудлуудын талаар зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг.

Их Британи

Их Британи улсын парламентын Нийтийн танхим /House of Commons/ нь байнгын ба түр хороодтой ба байнгын хороод нь Нийтийн танхимын хороо, Тусгай хороо, Тусгай бус хороо гэж гурван төрөлд хуваагдана. Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг Тусгай хороод гүйцэтгэдэг ба эдгээр хороодын үүрэг нь гол яамдын үйл ажиллагааг хянах явдал учраас тэдгээр нь Батлан хамгаалах асуудлаархи тусгай хороо, Гадаад харилцааны тусгай хороо, Дотоод хэргийн тусгай хороо гэх мэт засгийн газрын бүтцийн дагуу байгуулагдсан нийт 14 тусгай хороо ажилладаг. Тусгай хороод нь хоёр танхимд хоёуланд нь үйлчилэх ба засгийн газрын яамны ажлаас эхлэн эдийн засгийн асуудал хүртэлх бүх хүрээнд хяналт шалгалт хийж тайлан гаргана.

Парламентын ажлын албаны **Танхим ба байнгын хороодын үйлчилгээний департаментын Хороодын газар нь /Committee Office/** Нийтлэг хууль тогтоомжын хороод болон Засгийн газрын байгууллагуудыг хянан шалгах үүрэгтэй Тусгай хороодын үйл ажиллагаанд туслана. Мөн Танхимын үйл ажиллагааны хяналт шалгалтыг чадавхижуулах зорилгоор Нийтийн танхимын Хороодын газрын бүрэлдэхүүнд **Хяналтын нэгжийг /Scrutiny unit/** байгуулсан байна.

Энэ нэгж нь Тусгай хороодод мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг ба ялангуяа санхүүгийн асуудал болон хуулийн төсөлд хийх хяналт, шалгалтад туслалцаа үзүүлдэг. Хяналтын нэгжид хуульч, нягтлан бодогч - санхүүч, эдийн засагч, статистицк зэрэг мэргэжилтэй нийт 14 албан хаагч ажилладаг.

Хяналтын нэгж нь гол төлөв хууль тогтоох болон санхүүгийн хяналт, зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд анхааран ажилладаг ба эдгээрийг доор авч үзье.

✓ **Хууль тогтоох үйл ажиллагааны хяналт шалгалт**

Хяналтын нэгжийн хууль тогтоох хяналт шалгалтын ажил нь хоёр төрөлд хуваагдана. Нэгд нь, энэхүү нэгж нь Тусгай хороодод хуулийн төслийг хянан шалгахад туслалцаа үзүүлнэ, хоёрт, хуулийн төслийг хэлэлцэхээр Лордын танхим болон Нийтийн танхимаас байгуулсан Онц яаралтай хамтарсан хороодод захиргааны туслалцаа үзүүлж, хуулийн болон процедурын талаар зөвлөгөө өгнө.

✓ **Санхүүгийн хяналт шалгалт**

Хяналтын нэгж нь Тусгай хороодод санхүүгийн өргөн хүрээний зөвлөгөө өгдөг талаар дээр дурьдсан. Санхүүгийн хяналтыг санхүү, төсвийн тооцоо хийх, яамдын санхүүгийн тайлан, тооцоог хянах, санхүүгийн нөөцийг урьдчилан тооцоолох, зарлагын хяналтыг гүйцэтгэх зэргээр системтэйгээр бүрэн дүүрэн хийж гүйцэтгэдэг байна.

Хяналтын нэгж нь мөн яамдаас гаргадаг санхүүгийн мэдээллийн чанарыг дээшлүүлэх, зааварчилгаа, танилцуулга бэлтгэх болон парламентын гишүүд, тэдгээрийн туслахуудад сургалт явуулах зэрэг ажилд Тусгай хороодтой хамтран ажиллах замаар санхүүгийн хяналт шалгалтын чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Үүний зэрэгцээ Хяналтын нэгж нь Танхимын бусад нэгж албадуудтай мөн хамтран ажилладаг. Тухайлбал, Спикерийн хороонд, Сонгуулийн Комиссын хяналт хийх, Байнгын хороодод хуулийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийхэд нь туслалцаа үзүүлдэг.

Түүнээс гадна Их Британы парламентад Парламентын Захиргааны Комиссарын буюу Парламентын Омбудсманы /Parliamentary Commissioner for Administration (Parliamentary Ombudsman)/ офис ажилладаг ба 1967 оны “Парламентын Комиссарын тухай” /The Parliamentary Commissioner Act 1967/ хуулиар Парламентын Омбудсмэн нь төв засгийн газрын яамны болон орон нутгийн засаг захиргаа зэргийн захиргааны үйл ажиллагааг мөрдөн шалгах үүрэгтэй болохыг хуульчилсан байна. Офис нь засгийн газраас биеэ даасан, хараат бус, иргэний үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны талаархи иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хянан шалгадаг байна.

Түүнчлэн тус парламентад засгийн газар хөрөнгө мөнгийг хэрхэн зарцуулж байгаа

байдалд хяналт тавих үүрэг бүхий Ерөнхий хянагч ажилладаг. Тэрээр парламентын албан тушаалтан бөгөөд парламентын өмнө хариуцлага хүлээдэг.

ХБНГУ


ХБНГУ-д парламентын хяналт шалгалт нь Бундестагын чухал чиг үүргийн нэг юм. Тус улсад парламентын хяналт шалгалт нь хууль тогтоомж болон төсвийн хяналт шалгалт, бие даасан гишүүдийн хяналт шалгалт, төрөл бүрийн байгууллагуудын хяналт шалгалт гэм мэт олон хэлбэрээр хэрэгждэг байна¹⁶. Бундестагт парламентын төрийн нарийн бичгийн дарга гэсэн албан тушаалтан байдаг бөгөөд энэхүү албан тушаалтан нь парламентын гишүүн бөгөөд зарим голлох яамны төрийн нарийн бичгийн даргын албыг давхар хашдаг байна. Үндсэн чиг үүрэг нь парламент дахь засгийн газрын цагаар Засгийн газрыг төлөөлөн асуултанд хариулж, засгийн газар, парламентын бүлгүүд, хороодын харилцаа холбоог хангана.

Холбооны Засгийн газрын хяналтыг Парламентын **Өргөдлийн хороо** мөн хариуцан гүйцэтгэдэг. ХБНГУ-ын Үндсэн хуульд хүн бүр Парламентад санал хүсэлт эсвэл гомдлоо бичгээр илэрхийлэх эрхтэй хэмээн хуульчилсаны дагуу иргэд, хувь хүнээс болон хамт олноос парламентад гаргасан өргөдөл, гомдлыг тус хороо хүлээн авч засгийн газартай холбоотой өргөдөл, гомдлыг холбогдох засгийн газрын байгууллагад шилжүүлдэг ба хорооны хурлаар уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаархи мэдээллийг сонсдог байна.

Парламентын хяналтын нэг чухал чиглэл нь **Мөрдөн шалгах хороо** байгуулан ажиллаж мөрдөн шалгах ажиллагаа явуулан үр дүнг нь илтгэл хэлбэрээр дүгнэн бэлтгэж парламентын хэлэлцэх асуудалд оруулан хэлэлцдэг. Мөрдөн шалгах хороог холбооны засгийн газар, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гарсан хууль бус үйл ажиллагаа, дутагдалын талаар шүүмжлэл гарсан тохиолдолд ихэвчлэн сөрөг хүчний санаачлагаар байгуулан ажиллуулдаг байна.

Германы Бундестагийн дээр дурьдсан хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго бүхий 6 байгууллага бүтэц парламентад ажилладаг ба тэдгээрийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь парламентын ажлын албаны Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн дарга нарын газар, Өргөдөл, хүсэлт хариуцсан газар мэргэжлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг.

Зураг



¹⁶ Мөн тэндээс үзнэ үү

Secretariat PD 5 буюу Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн даргын газар нь Парламентын хяналтын хороо, G10 комисс, ZFdG комисс /Гаалийн мөрдөн шалгах Үйлчилгээний Актын дагуу байгуулагдсан/, Хамтарсан хороодоос /Үндсэн хуулийн 53т заасны дагуу/ бүрдэнэ.

Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн даргын газар буюу Secretariat PD 5 нь Холбооны засгийн газрын оюуны үйлчилгээг хянан шалгах үүрэгтэй хэд хэдэн парламентын байгууллагуудад туслалцаа үзүүлнэ. Эдгээр байгууллагууд нь нууц хурлуудад товч мэдээлэл хийх ба дээрх гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаагаар Бундестагийн хяналт хийх чадварыг хангах зорилго бүхий үйл ажиллагаа явуулдаг.

Өргөдөл, хүсэлт хариуцсан газар нь өргөдлийн байнгын хорооны нарийн бичгийн даргын газар болон хэд хэдэн яамдыг нэгтгэн хариуцдаг нийт 5 хэлтэстэй болно. Тус газар нь Өргөдлийн хорооны хүлээн авсан өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэх, Хорооны хурлыг зохион байгуулах, хүлээж авсан өргөдлийг шийдвэрийн төсөлтэй нь хамтатган жагсаалтаар сар бүр Бундестагийн чуулганд оруулж тайлагнасан Тайлангуудыг хэвлэж тараах, өргөдөл гаргагчид гаргасан шийдвэрийг мэдэгдэх, тэдэнд зөвлөлгөө өгч, туслалцаа үзүүлэх зэрэг ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг ба Бундестагт гаргасан хууль болон захиргааны шийдвэр нь алдаатай, орхигдуулсан, шударга бус байсныг илрүүлж, эрхзүйн орчныг сайжруулахад чухал үүрэгтэй Өргөдлийн хорооны үйл ажиллагаанд оролцдог ажээ.

* * *

Дүгнэлт

- Дээр авч үзсэн орнуудын туршлагаас үзэхэд парламентын хяналт шалгалтын, түүн дотроо мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй Байнгын хорооны статустай хороо, комисс, офис болон тусгай албан тушаалтан ажиллаж байгаа бол манайд УИХ-ын Байнгын хороод, дэд хороод хянан шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй, харин тусгайлан мөрдөн шалгалт явуулах эрх, үүрэгтэй бүтэц үгүй байна.
- Парламент хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх хэлбэрийн хувьд засгийн газрын цаг, асуулга, асуулт тавих, төсвийн хяналт, захиргааны зөрчлийг шалгаж санал дүгнэлт гаргах зэрэг ижил төстэй явагдаж байгаа боловч захиргааны зөрчлийн талаархи өргөдөл гомдлыг барагдуулах, шийдвэрлэх, төр, нийтийн эрх ашгийн үүднээс парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах тал дээр эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм, үр дүнг тооцоход ялгаатай анхаарвал зохих асуудал ажиглагдаж байна.
- Парламентын ажлын албадын зүгээс хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлдэг бие даасан нэгжтэй бөгөөд тэд парламентын хяналт шалгалт хийх чадварыг нь хангах, дээшлүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа явуулж байна.

Санал

- УИХ –ын Хянан шалгах **Ерөнхий чиг үүргийн** дагуу парламентын зохион байгуулалтын дотоод бүтцэд Хяналт шалгалтын хороог шинээр байгуулж, түүнд, Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг зохион байгуулах ажлыг хариуцуулах
- Парламентын хяналт шалгалтын нэг гол хэлбэр болсон мөрдөн шалгах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын талаар анхаарах

- УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийг сайжруулах зорилгоор Тамгын газрын бүтцэд хяналт шалгалтын бүтэц байгуулж, чиг үүргийг тодорхойлох зэрэг болно.

* * *

Хавсралт 1

Гадаадын зарим орны парламентын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжүүд, тэдгээрийн чиг үүрэг

Улс ба Парламентын танхимын нэр	Эрх зүйн зохицуулалт	Хяналтын чиг үүрэгтэй парламентын нэгжийн нэр	Парламентаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлдэг хэлбэр	Парламентын Ажлын албанаас хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг бүтцийн нэгж, чиг үүрэг
Шинэ Зеланд Төлөөлөгчдийн танхим	Төлөөлөгчдийн танхимын Дэг, Омбудсмэний тухай хууль, 1975 он	- Тусгай хороод - Ерөнхий аудиторын офис - Омбудсмэний офис - Парламентын байгаль орчны комиссарын офис	Засгийн газрын сайд нарт асуулт, асуулга тавих, тайлан илтгэл хэлэлцэх, санхүүгийн шалгалт хийх, өргөдөл, гомдлыг хянан шалгах, тулгамдсан асуудлаар мөрдөн шалгалт хийх, захиргааны шийдвэрийн талаархи гомдлыг хянах, ЗГ-т итгэл үзүүлэх эсэх асуудал зэрэг болно.	Тусгай хороодын офис: хяналт шалгалтын болон мөрдөн шалгах үүрэгтэй холбоотой ажлыг хийж гүйцэтгэхэд зохион байгуулах үүрэгтэй оролцоно. Мөн тусгай хороодын гишүүдэд дүрэм, журам, парламентын процедурын практикаар зөвөлгөө өгнө.
Их Британи Нийтийн танхим	Нийтийн танхимын Дэг, Захиргааны комиссарын тухай хууль, 1967 он	- Нийт 14 Тусгай хороод ажилладаг - Парламентын Захиргааны комиссар - Ерөнхий хянагч	Засгийн газрын сайд нарт асуулт, асуулга тавих, Тусгай хороод засгийн газрын бодлогод салбар бүрээр хяналт шалгалт хийнэ. Захиргааны асуудлаар мөрдөн шалгалт явуулна. Санхүүгийн хяналт, шалгалт хийнэ.	Нийтийн танхимын хороодын газрын Хяналтын нэгж: Тусгай хороодод хуулийн төслийг хянан шалгахад туслах, санхүүгийн талаар зөвөлгөө өгөх, гишүүд, албан хаагчдад сургалт явуулах, Онц яаралтай хамтарсан хороодод захиргааны туслалцаа, хуулийн болон процедурын талаар зөвөлгөө өгөх,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Судалгааны эмхтгэл, XII боть

ХБНГУ	<p>Үндсэн хууль, Германы Бундестагийн Дэг,</p> <p>Зэвсэгт хүчин хариуцсан комиссарын тухай хууль,</p> <p>Тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих парламентын хяналтын тухай хууль, 1978 он</p>	<p>-Тусгай статустай хороод</p> <p>-Өргөдлийн хороо</p> <p>-Парламентын хяналт шалгалтын комисс</p> <p>-G 10 комисс</p> <p>-ZFdG комисс</p> <p>-Хувийн орон сууцны дуу чимээний хяналтын хороо</p> <p>-Зэвсэгт хүчин хариуцсан комиссар</p> <p>-Хяналтын хороо</p>	<p>Засгийн газрын цаг, төсвийн хяналт, шалгалт, өргөдөл, гомдлыг хянан шалгах, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, засгийн газрын байгууллагуудаас мэдээлэл авах, тусгай албадын үйл ажиллагаанд хяналт тавих, тайлан, илтгэл хэлэлцэх</p>	<p>Secretariat PD 5 буюу Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн даргын газар, Өргөдөл, хүсэлт хариуцсан газар: Secretariat PD 5 нь Холбооны засгийн газрыг хянан шалгах үүрэгтэй хэд хэдэн парламентын байгууллагуудад туслалцаа үзүүлнэ. Эдгээр байгууллагууд нь нууц хурлуудад товч мэдээлэл хийх ба дээрх гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаагаар Бундестагийн хяналт хийх чадварыг хангах зорилго бүхий үйл ажиллагаа явуулдаг. Ө/Хгазар нь Өргөдлийн хорооны хүлээн авсан өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэх, Хорооны хурлыг зохион байгуулах, хүлээж авсан өргөдлийг шийдвэрийн төсөлтэй нь хамтатган жагсаалтаар сар бүр Бундестагийн чуулганд оруулж тайлагнасан Тайлангуудыг хэвлэж тараах, өргөдөл гаргагчид гаргасан шийдвэрийг мэдэгдэх, тэдэнд зөвлөлгөө өгч, туслалцаа үзүүлэх зэрэг ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг.</p>
Монгол Улсын Их Хурал	<p>Үндсэн хууль, УИХ-ын тухай хууль, УИХ-ын Дэгийн тухай хууль</p>	<p>-УИХ-ын Байнгын хороод</p> <p>-Тусгай хяналтын дэд хороо</p> <p>-Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо</p> <p>-Өргөдөл гомдлын дэд хороо</p> <p>-Төсвийн зарлагын хяналтын дэд хороо</p> <p>-Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо</p>	<p>Засгийн газрын ба УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, тэдгээрт асуулга, асуулт тавих, түүний хариуг чуулганаар хэлэлцүүлэх, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор байгуулан ажиллуулж болно. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын дарга, гишүүнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж санал, дүгнэлт гаргах.</p>	<p>Байнгын хороодын ажлын алба:Хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах ажлыг төлөвлөх,гүйцэтгэлийг хянах, Хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай зохих журмын дагуу харилцах, хяналт тавих, асуулт, асуулга тавих ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хариуг сонсох асуудлыг зохион байгуулах, УИХ-аас тогтоолоор өгөгдсөн үүргийн биелэлтэнд хяналт тавих, ЗГ, холбогдох бусад байгууллагад өгөх чиглэл,санал дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулж албажуулах, Хорооны даргад ирсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж хариу бэлтгэн явуулах, Захиргаа боловсон хүчний хэлтэс:Байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, баримт материал, иргэдийн захидал,УИХ-ын веб хуудсаар ирүүлсэн болон амаар тавьсан санал хүсэлт, гомдол,мэдээллийг хүлээн авч бүртгэх, тэдгээрийг холбогдох албан тушаалтанд хүргэх ажлыг зохион байгуулах, хариутай бичиг, өргөдөл, санал, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавих</p>

* * *

Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа
(Parliamentary investigation, парламентское расследование)

Энэхүү үйл ажиллагааг нь парламентын хянан шалгах чиг үүргийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа нь парламентын хяналтанд байдаг засгийн газрын байгууллагын нийтийн эрх ашгийн хохироосон, улс төрийн шинж чанартай хууль бус үйл ажиллагааг шалгах зорилгоор хийгддэг болно.

Парламентын мөрдөн шалгалтыг хэрэгжүүлэх эрх зүйн механизм нь, гадаадын туршлагаас харахад, бүхэлдээ үндсэн хууль ба хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны дэг процедурыг тогтоосон хууль, мөн түүнчлэн бие даасан тусгай хууль батлах гэх мэт олон аргаар тодорхойлогддог. Үүнд:

- Үндсэн хуулийн агуулгын тухайлсан тодорхой заалтаар парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны үндсийг тавьж эрхийг нээж өгсөн байх;
- Парламентын тухай хуулийн агуулгад парламентын шалгалтын эрхийг нээсэн заалт оруулаад зогсохгүй, тухайн шалгалтыг чухам яаж зохион байгуулж явуулах тухай дэлгэрүүлж тодруулсан байх;
- Төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр гаргах процесс (Дэг) –ийн тухай хуулийн агуулгад парламентын байцаан дүгнэх ажиллагааны талаар тусгаж хуульчилсан байх;
- Төрийн дээд байгууллагаас парламентын шалгалт хийх, мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулах горимыг бүхэлд нь нэгтгэж зохицуулсан тусгай хуультай байх зэрэг болно.

Германы Үндсэн хуулинд парламентын мөрдөн шалгах комиссыг хэрхэн томилох, засаглалын бусад механизмтай комиссын үйл ажиллагааг холбох, комиссын ажлын дүнг ашиглах талаар заасан байна. Иймэрхүү утга санаа бүхий зүйл заалтууд Грек, Испани, Итали, Швейцарь, Япон, Португалийн болон бусад олон орны Үндсэн хуулинд суужээ¹⁷.

Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулдаг улс орнууд ч байна. Орос, Дани, Люксембург, Литва –д асуудал тусгай хуулиар, эсхүл тухайн орны үндэсний парламентын тухай хуулийн холбогдох бүлэг заалтаар зохицуулагддаг. Ер нь парламентын мөрдөн шалгах чиг үүргийг хуульчлан хэрэгжүүлдэг улс болгон парламентын явуулах процедур үйлдлийг зааж зохицуулсан Дэгийн тухай хуульдаа асуудлыг бас нарийвчлан тусгадаг ажээ. Парламентын бие даасан мөрдөн шалгах эрхийг Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн Беларусь, Гүрж, Молдав, Украин, Узбекистан, Армен зэрэг орнуудад баталгаажуулсан байна.

* * *

¹⁷ Хавсралтыг үзнэ үү

Европын Холбооны зарим улсууд болон АНУ, Японы парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны Үндсэн хуулийн зохицуулалтын талаархи лавлагаа

Улсын нэр	Улсын үндсэн баримт бичигт парламентын мөрдөн шалгах ү/а-г тусгасан байдал	Үндсэн баримт бичигт Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааг нарийвчлан тусгасан байдал	Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны нарийвчилсан дэг	Парламентын мөрдөн шалгах ү/а-ны субъект
Австри	Үндсэн хуулийн 53 дугаар зүйл	Байхгүй	Үндэсний зөвлөлийн дэгийн тухай Холбооны хууль	Мөрдөн шалгах хороо
Бельги	Үндсэн хуулийн 56 дугаар зүйл	Байхгүй	Үндсэн хуульд заагаагүй	Үндсэн хуульд заагаагүй
Их Британи	Заалт байхгүй		1967 оны хуулийн дагуу Захиргааны комиссар	Захиргааны комиссар
ХБНГУ	ХБНГУ –ын Үндсэн хуулийн 44, 45-а-2	Мөрдөн шалгах хороо байгуулах дараалал зарчим /ҮХ-ийн 44-1/ Төр засгийн байгууллагатай Хамтран ажиллах /ҮХ-ийн 44-3/ Парламентын мөрдөн шалгалтын үр дүнг ашиглах /ҮХ-ийн 44-4/	Мөрдөн шалгах үйл ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтын дагуу явуулах	Батлан хамгаалах асуудлаарх хороо / мөрдөн шалгах хорооны эрхтэй /
Грек	Үндсэн хуулийн 68 дугаар зүйл	Мөрдөн шалгах комисс байгуулах журам /ҮХ-ийн 68-2,3/	Мөрдөн шалгах комиссын ажиллах журам, бүтэц бүрэлдэхүүнийг Парламентын дүрмээр тодорхойлно	Мөрдөн шалгах комисс
Дани	Үндсэн хуулийн 51 дүгээр зүйл	Харилцан мэдээлэл солилцох харилцан /ҮХ –ийн 51 дүгээр зүйл/	ҮХ-нд заагаагүй	Онц чухал асуудлаар мөрдөн шалгах ү/а явуулах хороод
Испани	Үндсэн хуулийн 76 дугаар зүйл	Мөрдөн шалгах комисс байгуулах журам /ҮХ-ийн 76-1/ Парламентийн мөрдөн шалгах ү/а-ны үр дүнг ашиглах /ҮХ-ийн 76-1/ Парламентын шаардлагаар ирэх үүрэгтэй байх /ҮХ-ийн 76-2/	Үндсэн хуулинд заагаагүй	Мөрдөн шалгах комисс
Итали	Үндсэн хуулийн 82 дугаар зүйл	Парламентын мөрдөн шалгалт явуулах шалгуур /ҮХ-ийн 82-1/ Парламентын мөрдөн шалгалт явуулах комиссыг байгуулах журам /ҮХ-ийн 82-2 Парламентын мөрдөн шалгалт явуулах бүрэн эрх, хязгаарлалт/Шүүхийн бүрэн эрх ба хязгаарлалттай адил// ҮХ-ийн 82-2/	Үндсэн хуулинд заагаагүй	Төрийн эрх ашгийн үүднээс мөрдөн шалгалт явуулах комисс
Люксембург	Үндсэн хуулийн 64 дугаар зүйл	байхгүй	Хуулиар зохицуулсан	ҮХ-д заагаагүй

Португал	Үндсэн хуулийн 181 дүгээр зүйл	Парламентын мөрдөн шалгах түр комисс байгуулах журам /ҮХ –ийн 181 зүйлийн 2,4,6/ Парламентын мөрдөн шалгах ү/а-ны журам / ҮХ-ийн 181-3/ Парламентын мөрдөн шалгалтын явц хамтран ажиллах журам/ҮХ-ийн 181-3/ Парламентын мөрдөн шалгах комиссын бүрэн эрх / шүүхтэй адил эрх эдэлнэ// ҮХ-ийн 181-5/	Үндсэн хуульд заагаагүй	Парламентын мөрдөн шалгах түр комисс
Франц	Заалт үгүй		Тусгай хуультай	
Швед	Үндсэн хуулийн 4 дүгээр зүйл	Тусгай бүрэн эрхт Үндсэн хуулийн комиссын үйл ажиллагааны процесс/ҮХ-ийн 12 дугаар зүйл/ Сонгуулийн асуудлаар парламентын мөрдөн шалгалт явуулах асуудлын хүрээ, шалгалт хийх үндэслэл, үр дүн /ҮХ-ийн 4-7/	Риксдагийн тухай хууль	Сонгуулийн шалгалтын хороо, Үндсэн хуулийн комисс
АНУ	Заалт үгүй	1991.02.28 өдрийн Сенатын 62 дугаар тогтоол		Сенатын байнгын дэд хороо
Япон	Үндсэн хуулийн 62 дугаар зүйл	Парламентын мөрдөн шалгалт явуулах асуудлыг тодорхойлох шалгуурууд /ҮХ-ийн 62 дугаар зүйл/ Парламентын шаардлагаар тэмдэглэлээ ирүүлэх буюу хүрэлцэн ирэх үүрэгтэй		
Монгол	Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-ийн 8-д УИХ-ын “... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” онцгой бүрэн эрхийг хуульчилсан	Заалт үгүй	Тусгайлсан хууль үгүй	УИХ-ын Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэг

* * *

Хавсралт 3

ХБНГУ-ын парламентын хяналт, шалгалт Хяналт шалгалтын хэлбэрүүд

Хууль тогтоомж болон төсвийн хяналт шалгалт

Засгийн газрын хяналт шалгалт нь Бундестагийн чухал үүрэг хариуцлагуудын нэг билээ. Энэ үүрэг нь хууль батлах үйл ажиллагаатай холбоотой. Засгийн газраас гаргасан хуулийн зүйл заалт бүрийг парламентаар хэлэлцэх ба олонхын саналыг авах шаардлагатай байдаг. Парламент нь мөн засгийн газрын төсвийн баримтлалыг хянан. Холбооны сангийн сайд

нь хуралдаанаар Бундестагд болон Засгийн газарт тайлангаа тавина.

Бие даасан гишүүдийн хяналт шалгалт

Парламентын гишүүд нь өөрийн ажил болон засгийн газрын төлөвлөгөө мөн чухал асуудлын талаар мэдээлэл авах боломжтой. Эдгээр арга хэмжээг заавал парламентын олонхоор дэмжих шаардлагагүй. Жишээлбэл бие даасан гишүүд засгийн газарт амаар болон бичгээр асуулт тавьж болно.

Төрөл бүрийн байгууллагуудын хяналт шалгалт

Бундестаг нь төрөл бүрийн байгууллагуудыг засгийн газрын ажлыг хянаж шалгуулахаар байгуулдаг. Эдгээр байгууллагуудын зарим нь байнгын байх ба үүнд байнгын хороод болон Парламентын хяналт шалгалтын хороо /Parliamentary Control Panel/ орно. Харин бусад байгууллагууд нь зөвхөн тулгамдсан чухал арга хэмжээнүүдэд хяналт шалгалт хийх зорилготойгоор байгуулагддаг. Зарим тохиолдолд энэ төрлийн байгууллагыг байгуулахад Германы Бундестагийн гишүүдийн 25 хувийн саналын дэмжлэг шаардагддаг. Эдгээр байгууллагуудад мөн улс төрийн болон хүнд суртал, албан тушаалын гэмт хэргийг шалгуулахаар байгуулдаг хяналтын хороод орно.

ЗАСГИЙН ГАЗРЫН АЖЛЫГ ХЯНАН ШАЛГАХААР БАЙГУУЛАГДСАН БАЙГУУЛЛАГУУД

Хороод, комиссууд, комиссарууд

Германы Бундестагийн гишүүд засгийн газрын ажил, төлөвлөгөөний талаар мэдээлэл авах болон өөрсдийн саналаа хуралдаанд илэрхийлэх төрөл бүрийн боломжтой. Түүнчлэн Бундестагийн сонгуулийн жил бүр засгийн газрын хяналтыг хийх зөвшөөрөл бүхий байгууллагуудыг байгууна. Үүнд:

- Байнгын хороод
- Тусгай салбаруудыг хянан шалгах аар байгуулсан байгууллага
- Хяналтын хороод

○ Байнгын хороод

Бундестагийн байнгын хороод тус бүрдээ холбооны тодорхой яамыг хариуцсан байхаар зохион байгуулагдсан. Тиймээс тэдгээр нь бодлогын эсвэл үйл ажиллагааны тогтоосон тодорхой хүрээнд асуудлыг шийдвэрлэнэ. Хороод өөрийн хяналтын үйл ажиллагаагаа хууль тогтоох үйл ажиллагааны оролцоотойгоор шууд бусаар гүйцэтгэнэ. Гэхдээ мөн тэдэнд хяналт шалгалтын шууд эрхүүд байдаг. Жишээлбэл тэд холбогдох холбооны яамны төлөөлөгчдөөс тухайн хуулийн төслүүдэд тайлан гаргахыг шаардах эрхтэй.

○ Тусгай статустай байнгын хороод

Зарим байнгын хороод нь засгийн газрын холбогдох хяналтын үйл ажиллагааны тусгай статус эдэлнэ. Жишээлбэл Гадаад хэргийн хорооны үндсэн үүрэг нь засгийн газрын гадаад бодлогын хянан шалгалт байна.

Зэвсэгт хүчин хариуцсан парламентын комиссар, Батлан хамгаалах хороо, мөн Батлан хамгаалахын сайд нь зэвсэгт хүчний хяналтыг хангах зорилготой гэж Үндсэн хуульд заасан байдаг.

Төсвийн хороо нь төсвийн нөөцийн зөвшөөрлийн шийдвэр гаргахад чухал үүрэгтэй тул энэ нь хамгийн их эрх мэдэлтэй хороо байдаг.

○ **Өргөдлийн хороо /Petitions committee/**

Өөр нэг байнгын хороо нь Өргөдлийн хороо бөгөөд энэ нь мөн чухал байр суурь эзэлдэг. Иргэд нь засгийн газарт шууд нөлөөлөх боломжтой. Үндсэн хуульд зааснаар хүн бүр Парламентад санал хүсэлт эсвэл гомдлоо бичгээр илэрхийлэх эрхтэй. Тусгай эрх эдэлдэг өргөдлийн хороо нь иргэдээс ирүүлсэн захидлуудыг Германы Бундестагийн ерөнхийлөгчид дамжуулан хүргэнэ.

○ **Тусгай салбаруудад хяналт шалгалт хийхээр байгуулагдсан байгууллагууд**

Бундестагийн байнгын байгууллага нь мөн бодлогын тусгай салбаруудыг хянахаар байгуулагдсан байгууллагуудыг оруулна. Тэдгээр нь засгийн газрын тодорхой хүрээний ажлыг хянана. Парламентын хяналт шалгалтын хороо нь Холбооны оюуны үйлчилгээний үйл ажиллагааг хянана. Энэ хорооноос байгуулсан G10 Комисс нь захидал, шуудан холбоо, харилцаа холбооны хувийн нууцлалд хязгаарлалт хийх талаар шийдвэр гаргах үүрэгтэй.

Тусгай салбаруудад хяналт шалгалт хийхээр байгуулагдсан байгууллагууд нь засгийн газраас ерөнхий үйл ажиллагаануудын талаар мэдээлэл, түүнчлэн тодорхой чухал үйл ажиллагааны талаар мэдээлэл шаардах боломжтой. Хяналт хийх зорилготой эдгээр байгууллагуудад мэдээллээ өгөх болон ажилчдаас ярилцлага авах зөвшөөрлийг тэдэнд өгөх, агентууд руу зочлоход засгийн газраас зөвшөөрөл олгох ёстой.

➤ **Парламентын хяналт шалгалтын комисс /The Parliamentary Control Panel (PKGr)/**

Парламентын хяналт шалгалтын комисс нь Холбооны түвшинд оюуны үйлчилгээний ажлыг хянах үүрэгтэй. Энэхүү Комисс нь холбооны оюуны үйлчилгээний ерөнхий үйл ажиллагаа болон ялангуяа чухал үйл ажиллагааны талаар нарийвчилсан мэдээлэл өгөхийг Холбооны засгийн газраас шаардаж болно.

➤ **G 10 Комисс /G 10 Commission/**

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу G10 Комисс нь шуудан холбоо, харилцаа холбооны хувийн нууцлалд хязгаарлалт хийх шаардлагатай талаар шийдвэр гаргана.

➤ **ZFdG комисс /ZFdG Panel /**

ZFdG комисс нь Гаалийн хяналт шалгалтын үйлчилгээний актын / Customs Investigation Service Act/ дагуу байгуулагдсан. Герман улсын гаалийн хяналт шалгалтын үйлчилгээний төв офис нь Гадаад Худалдааны Төлбөрийн Акт /Foreign Trade and Payments Act/ болон Дайны зэвсгийн хяналтын актын /War Weapons Control Act/ дагуу гэмт хэргийг мөрдөн шалгана. Тиймээс энэ комисс нь шуудан холбоо, харилцаа холбооны хувийн нууцлалыг хязгаарлах эрхтэй. Дээр дурьдсан Үндсэн хуулийн заалтын дагуу үндсэн эрхүүдийг зөрчсөн эдгээр үйл ажиллагааг Гаалийн хяналт шалгалтын үйлчилгээний актын 23-р хэсгийн дагуу ZFdG Комиссоор шалгуулна.

➤ **Хувийн Орон Сууцан дахь Дуу Чимээний Хяналт Шалгалтын Хороо /Committee for the Scrutiny of Acoustic Surveillance of the Private Home/**

Үндсэн хуулийн өөрчлөлттэйгөөр зөвхөн ноцтой гэмт хэргийн тохиолдолд Хувийн орон сууцанд дуу чимээний хяналт шалгалтыг хийж болно. Энэхүү үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хуулийн 13-6д заасны дагуу парламентаар хяналт шалгалт хийлгэнэ.

○ **Хяналтын хороод** /Committees of inquiry/

Хяналтын хороо нь зөвхөн чухал тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр Германы Бундестагийн гишүүдийн 25 хувийн саналын дэмжлэгийг авсанаар байгуулагддаг. Хяналтын хороо нь Холбооны засгийн газар, Бундестаг, захиргааны улс төрийн болон хүнд суртал албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгаж хяналт хийнэ. Хяналтын хорооны гол ажил нь нотлох баримт цуглуулах ажил байна. Хяналтын хороо нь түүнд байгаа баримт материалыг шалгах, гэрчүүдийг шалгах, амлалт авах, ярилцлага авч болно. Түүнчлэн шүүх, захиргааны эрх мэдлээс гүйцэтгэх туслалцаа хүсч болно. Хяналт хийж дууссаны дараа тайланг хэвлэн гаргаж мөн Бундестагд хэлэлцүүлэг хийнэ.

БАТЛАН ХАМГААЛАХ ХОРОО /Defence Committee/

Батлан хамгаалах хороо нь Холбооны Батлан хамгаалах яам болон түүний харьяат агентлагууд болох Зэвсэгт хүчин болон Холбооны Батлан Хамгаалах Захиргаатай хамтран ажилладаг парламентын байгууллага юм. Тиймээс түүний эрх мэдлийн хүрээ нь Бундестагийн аль ч хорооноос илүү их хүрээг хамардаг. Энэ хороо нь мөн батлан хамгаалахын төсвийн гүйцэтгэл болон түүнийг хэлэлцэхэд чухал үүрэгтэй. Үндсэн хуулийн 45д зааснаар Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын Комиссарын байгууллагыг парламентын хянан шалгах үйл ажиллагаанд Бундестагд туслалцаа үзүүлэхээр байгуулсан. Парламентын комиссарын хийсэн цэргийн өнөөгийн байдлын үнэлгээг түүний жилийн тайланд оруулах ба энэ нь мэдээллийн чухал эх үүсвэр болно, тиймээс хэлэлцүүлэгт оруулна.

ЗЭВСЭГТ ХҮЧИН ХАРИУЦСАН ПАРЛАМЕНТЫН КОМИССАР /The Parliamentary Commissioner for the Armed Forces/

Бундестагийг төлөөлөн ажиллана. Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын комиссарыг Бундестагийн гишүүд 5 жилийн хугацаатай сонгоно. Комиссар нь Бундестагийн гишүүн биш, төрийн албан хаагч ч биш ба, тэрээр тусгай байр суурьтай байна. Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын комиссар нь Германы Үндсэн хуульд заасны дагуу үндсэн эрхийг хамгаалах, парламентын хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд Бундестагд туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Комиссарын гүйцэтгэх эрх үүргүүд нь Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын комиссарын хуулинд заасан байдаг.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН